

FORCE MAJEURE /ГЭНЭТИЙН БУЮУ ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ/ БОЛОН HARDSHIP /ХҮНД НӨХЦӨЛ БАЙДАЛ/-ЫН БАТАЛГАА ГАРГАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий заалт

1. Энэхүү журам нь гэрээний талуудын хооронд гэрээний үүрэг биелүүлэх, биелүүлж байх явцад талуудын хүсэл зориг, хяналтаас гадуур урьдчилан таамаглах боломжгүй нөхцөл байдал бий болсон тохиолдолд МҮХАҮТанхимаас “Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл болон хүнд нөхцөл байдал”-ын баталгаа гаргуулах харилцааг зохицуулна.

1.1. Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог дараах утгаар ойлгоно. Үүнд:

1.2. “Force majeure” буюу гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл гэдэгт талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, урьдчилан сэргийлж, шинжлэх ухаан, техникийн ололтыг ашиглан даван гарах боломжгүй дараах саад тогтгор тохиолдсоны улмаас талууд гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүйд хүрэхийг ойлгоно:

1.2.1. зарласан болон зарлаагүй дайн, зэвсэгт мөргөлдөөн, бослого, гадаадын түрэмгийлэл, хорлон сүйтгэх үйл ажиллагаа, хувьсгал;

1.2.2. Байгалийн бүх төрлийн гамшиг /хүчтэй салхи шуурга, хар салхи, газар хөдлөлт, хүчтэй давалгаа, үер, цас зуд, аянга цахилгаан, гал түймэр гэх мэт/;

1.2.3. тэсрэлт, дэлбэрэлт, машин, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн эвдрэл, цахилгааны ноцтой гэмтэл;

1.2.4. бүх төрлийн хязгаар хориг, хариуцлагаас чөлөөлөгдөх хүсэлтэй талын аж ахуйн нэгжид тохиолдсон ажил зогсолт, ажил хаялт гэх мэт;

1.2.5. төрийн албан тушаалтны хуулийн дагуух болон хууль бус үйлдэл, эс үйлдэл, эрх зүйн акт, тушаал, захирамж, ажлын байр татан буугдах, эд хөрөнгө дайчлан хураах, нийгэмчлэх;

1.3. “Hardship” буюу хүнд нөхцөл байдал гэдэгт хууль эрх зүй, улс төр, эдийн засгийн шинжтэй шалтгааны улмаас талууд эдийн засаг, санхүү, төлбөрийн чадваргүй болох, гэрээний үүргээ хэрэгжүүлэхэд илт хохиролтой, алдагдалтай, ашиггүй байх зэргээс болж гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй болохыг;

1.4. “Баталгаа” гэдэг нь МҮХАҮТанхим тухайн хувь хүн, хуулийн этгээд, байгууллага гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлтэй тулгарсан, хүнд нөхцөлд орсныг гэрчилж, баталгаажуулж байгаа гэрчилгээг хэлнэ.

1.5. “Хүсэлт гаргагч” гэж гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл болон хүнд нөхцөл байдлын тодорхойлолт гаргуулахаар хүсэлт гаргасан гэрээний аль нэг тал байна.

1.6. “Экспортлогч” гэж Монгол Улсын гаалийн нутаг дэвсгэрээс буцаан оруулах үүрэг хүлээхгүйгээр гүйлгээнд чөлөөтэй барааг гаргаж байгаа хувь хүн, хуулийн этгээд, байгууллагыг хэлнэ.

1.7. “Импортлогч” гэж бараа, бүтээгдэхүүн Монгол Улсын хилээр импортоор оруулж байгаа хувь хүн, хуулийн этгээд, байгууллагыг хэлнэ.

Хоёр. Баталгаа гаргах

2.1. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл болон хүнд нөхцөл байдал”-ын баталгаажуулалтыг гаргахдаа Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль болон Монгол улсын нэгдэж орсон олон улсын гэрээ, конвенци, олон улсын эрх зүйн бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, бизнесийн тогтсон заншлын хэм хэмжээ, талуудын хооронд байгуулсан гэрээ болон үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан гаргасан төрийн эрх бүхий албан тушаалтан, байгууллагын хэм хэмжээ тогтоосон актыг удирдлага болгоно.

2.2. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл болон хүнд нөхцөл байдлын тодорхойлолтыг гэрээний аль нэг талын хүсэлтээр, түүнд үндэслэн МҮХАҮТ-ын дэргэдэх Монголын олон улсын ба үндэсний арбитраас гаргасан дүгнэлтийн дагуу Экспортыг дэмжин хөгжүүлэх хэлтэст гаргана.

Баталгааг гаргуулагч нь дараах шаардлагуудыг хангасан байх ёстой. Үүнд:

2.2.1. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл болон хүнд нөхцөл байдал”-ын баталгаа гаргуулахыг хүсэгч хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллага харилцааг зохицуулж буй гэрээндээ “Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл”, “Хүнд нөхцөл байдал”-ын заалтыг заавал тусгасан байх;

2.2.2. Үндсэн гэрээ болон түүнтэй холбоотой баталгааг гаргахад шаардлагатай баримтуудыг үнэн зөв, бүрэн гаргаж өгөх;

2.3. Хэрэв гадаад улсад үүссэн нөхцөл байдлын тухайд баталгаа гаргуулах бол баталгааг үнэн зөв гаргах үүднээс экспортлогч болон импортлогчоос шаардлагатай гэж үзсэн материалыг гаргуулна.

2.4. Хэрэв тухайн хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллага нь гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл болон хүнд нөхцөл байдлын заалт гэрээндээ тусгаагүй тохиолдолд МҮХАҮТанхим тэдгээрийн хүсэлтийн дагуу зөвхөн тодорхойлолт гаргаж өгч болно.

2.5. “Баталгаа” гаргуулахыг хүсэгч хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллага МҮХАҮТ-д дараах материалыг бүрдүүлж өгнө. Үүнд

- Гэрээний нотариатаар баталгаажуулсан хуулбар

- Баталгаа гаргуулах тухай хүсэлт
- Аж ахуйн нэгж бол улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар

2.6. Хүндэтгэн үзэх нөхцөл байдлын улмаас гэрээ эх хувиараа эсвэл нотариатаар баталгаажуулсан хуулбар хэлбэрээрээ хүсэлт гаргагч талд байхгүй бол тухайн гэрээний хуулбарыг үндэслэн баталгааг гаргаж өгч болох ба ингэхдээ гэрээний нөгөө талаас тодруулга авна.

2.7. Дараах тохиолдолд баталгаа гаргахгүй байж болно:

2.7.1. Баталгаа гаргах нөхцөл бүрдээгүй

2.7.2. Баталгаа хүсэгч шаардлагатай баримт бичиг, мэдээллээ гаргаж өгөөгүй

2.7.3. МҮХАҮТанхимын дэргэдэх МҮАрбитр ийм баталгаа гаргах шаардлагагүй гэж үзсэн.

2.8. МҮХАҮТанхим нь уг журмын 2 дугаар зүйлийн 2.4 дэх хэсэгт заасан материалыг бүрэн бүрдүүлж өгснөөс хойш ажлын 3 хоногт багтаан “Баталгаа”-г гаргаж өгнө.

Гурав. Бусад

3.1. Энэхүү журмыг 200.. оны ... дугаар сарын ...-наас эхлэн дагаж мөрдөнө.

3.2. Журамд МҮХАҮТ-ын Даргын тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулж болно.

---oOo---